

## Бусадтай байгуулсан гэрээ, хэлцлүүд

|  |   |
|--|---|
| Хятад улсын Жи Нан хотын нүүрсний хийн бүтээгдэхүүний үйлдвэртэй 2008 оны 1 сарын 22-нд үйлдвэр худалдаж авах гэрээ                        | NR-3200 маркын хагас кокс, шатдаг хийн зуух 2 комыг нэг бүрийг 1445 мянган юанаар худалдан авахаар гэрээ байгуулсан. Тоног төхөөрөмж орж ирж угсралтын ажил хийгдэж дуусаад байна. Үйлдвэрийн төлбөрийг 5 үетэйгээр төлөхөөр гэрээнд заасан ба одоогоор үйлдвэрийн төлбөрийн 85%-ийг төлөөд байгаа ба үйлдвэрийг хүлээлгэн өгөхөд 10%-төлнө, Үлдэгдэл 5%-ийг баталгаат хугацаа дууссаны дараа төлбөрийг төлнө. Баталгаат хугацаа нь ашиглалтанд орсноос хойш 1 жил. |
| Нийслэлийн агаарын чанарын албатай байгуулсан 2009 оны 7 сарын 21-ний өдрийн гэрээ   | Улаанбаатар хотын гэр хорооллын айл, өрхөд коксон түлш нийлүүлэх гэрээг байгуулсан. Жилд 30000 тн өндгөн шахмал түлш /брикет/ үйлдвэрлэн нийлүүлэх  |
| Мон Эко Тур ХХК-тай хагас коксын усан сан, тосон сангийн барилга, угсралтын ажлыг гүйцэтгүүлэхээр байгуулсан 2009 оны 8 сарын 31-ний гэрээ | Дархан –Уул аймагт байршилтай 875 ам.метр талбайтай, 4200 шоо метр эзэлхүүнтэй барилга угсралтыг гүйцэтгүүлэхээр нийт ажлын хөлс 14 сая төгрөг байхаар тохиролцон гэрээ байгуулсан. Тосон сан, усан сангийн бетон цутгалтын ажил дууссан акт үүлдэн хүлээж аваад байна.   |
| БиДиСЕК ХК-тай 2009 оны 9 сарын 11-нд байгуулсан Хамтран ажиллах гэрээ   | Энэ гэрээгээр “Нако түлш” ХК-ийн үйлдвэрийн угсралтын ажлыг дуусган, үйлдвэрийг ашиглалтанд оруулах, эргэлтийн хөрөнгийн санхүүжүүлэхэд шаардлагатай байгаа нэмэлт санхүүжилтийг татан төвлөрүүлэхэд зуучлахаар гэрээг байгуулав. Нако түлш ХК нь андеррайтеры үйлчилгээний хөлсөнд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 5%-д үйлчилгээний хөлс төлөхөөр харилцан тохиролцож хамтран ажиллаж байна.  |
| БиДиСЕК ХК-тай 2009 оны 9 сарын 16-нд хувьцаанд хөрвөх зээлийн гэрээ   | Нако түлш ХК-ийн нэмэлт санхүүжилтыг хувьцаанд хөрвөх зээл хэлбэрээр татан төвлөрүүлэх ТУЗ-ын 2009 оны 9 сарын 15-ны өдрийн №1 тоот тогтоолын үндэслэн “БиДиСЕК” ХК –тай 74,735,550 төгрөгийн хувьцаанд хөрвөх зээлийн гэрээ байгуулан 74,735,550 төгрөгийг зээлээд байна. Энэхүү санхүүжилтээр шатдаг хийн байгууламжын  |

угсралтын ажил, эрчим хүчний шугам татах, гүний худаг гаргах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

Эм И Ти Эф ХХК-тай 2009 оны 11 сарын 2-нд байгуулсан хувьцаанд хөрвөх зээлийн гэрээ

Нако түлш ХК-ийн нэмэлт санхүүжилтыг хувьцаанд хөрвөх зээл хэлбэрээр татан төвлөрүүлэх ТУЗ-ын 2009 оны 9 сарын 15-ны өдрийн №1 тоот тогтоолын үндэслэн “Эм И Ти Эф” ХК –тай 91,660,800 төгрөгийн хувьцаанд хөрвөх зээлийн гэрээ байгуулсан ба үүнээс 25,000,000 төгрөгийн зээлэн авч угсралтын ажилд ашиглаад байна.

“Шарын гол ХК –тай 2010 оны 4 сарын 5-нд хамтран ажиллах санамж бичиг зурсан

Энэхүү санамж бичгээр түүхий эд болох нүүрсийг 2 тал харилцан тохиролцож үнэ ханшыг тогтооно мөн нийлүүлэгч тал худалдан авагч талд жилд 120 мянган тонн хүртэлх хэмжээний УСТ-1089-90 стандартын шаардлагад тохирсон 50-300 мм-ийн технологийн нүүрсийг тогтмол нийлүүлнэ гэж заасан байна.

“Дархан өртөө-2” өртөөний “Дархан хөвөн” ХК-ийн салбар замд хийгдэх их засварын ажлыг гүйцэтгүүлэхээр 2010 оны 6 сарын 11-ны өдөр гэрээ байгуулсан.

“Нако түлш” ХК болон УБТЗ-ын Дархан дах төмөр замын 1-р ангитай 2010 оны 6 сарын 11 өдөр “Дархан хөвөн” ХК-ын салбар төмөр замд их засвар үйлчилгээ хийлгэхээр гэрээ байгуулан ажиллаж байна. Энэхүү гэрээг байгуулан ажлыг гүйцэтгүүлснээр салбар төмөр замыг сунгахад дөхөм болж төмөр замаар түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэх бүрэн боломжтой болж байгаа юм.